

Ирээд, Намайг дага ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гэр бүлийн үдэш, судраас суралцах—
зугаатай үйл ажиллагаа зэрэгт зориулав!

МОЗАЯ 4-6-Д ЗОРИУЛАВ

Түүний мөрийг даган алх

Мозая хаан “Их Эзэний замаар алхаж”, зарлигуудыг сахисан (Мозая 6:6). Цаасан дээр хөлийн мөрөө тойруулан зурж, хэлбэрээр нь хайчил. Хөлийн мөр дээрээ Есүс Христийг дагах нэг арга замыг бич. Хөлийн мөрөө Есүс Христийн жишээг санаж болох газарт тавь.

Бага насны хүүхдүүдэд:

Алхаад яв. Гишгэсэн газарт чинь гишгэх дадлага хүүхдээрээ хийлгэ. Бусдад туслах, баптисм хүртэх гэх мэт Есүс Христийн хийсэн зүйлсийг хийн Түүнийг дагаж болох тухай ярилц.



МОЗАЯ 7-10-Т ЗОРИУЛАВ

Бошиглогчийг дага

Бошиглогчид ирээдүйд болох зүйлийг харж чаддаг хэмээн Аммон заасан (Мозая 8:16-17-г үзнэ үү). 2-р хуудсыг нээж Ерөнхий чуулган дээр ерөнхийлөгч Нэлсоны хэлсэн захиасыг уншаарай. Тэр бидэнд юу гэж заасан бэ? Энэ талаар зураг зураад Найз сэтгүүл рүү илгээгээрэй.

Бага насны хүүхдүүдэд:

“Бошиглогчийг дага” дууг (Хүүхдийн дууны ном, 58) хүүхдүүдтэйгээ хамт дуул. Бошиглогч гэсэн үгийг дуулах бүрдээ бошиглогчийн зураг руу заа.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭЙТИ ДОКРИЛ

МОЗАЯ 11-17-Д ЗОРИУЛАВ

Харанхуйд гэрэлтэх гэрэл

Есүс Христ бол “хэзээ ч харанхуйлагдахгүй, төгсгөлгүй тэрхүү гэрэл” хэмээн Абинадай заасан (Мозая 16:9). Гэртээ ямар нэг зүйлийг нуу. Гэрлээ унтрааж хүн бүрийг харанхуйд нуусан зүйлийг олохыг хичээхэд урь. Дараа нь тэр зүйлээ дахиж нуугаад гэрлээ асаагаад эсвэл гар чийдэн ашиглан олохыг хичээ. Аль нь илүү амархан байсан бэ? Гэрэл чамд тусалсан шиг Есүс бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Бага насны хүүхдүүдэд:

Хүүхдээрээ гар чийдэн эсвэл дэнлүү асааж унтраах дадлага хийлгэ. Дараа нь Есүс Христ бол хэзээ ч нууж эсвэл унтрааж боломгүй гэрэл гэдгийг ярилц.



МОЗАЯ 18-24-Т ЗОРИУЛАВ

Эв нэгдлээр нэгдсэн зүрх

“Зүрх сэтгэлээ эв нэгдэл хийгээд нэг нэгнийхээ зүг хандсан хайранд нэгтгэ” (Мозая 18:21) хэмээн Алма заасан. Энэ нь бид хамтдаа ажиллаж, бие биедээ хайраа үзүүлэх хэрэгтэй гэсэн үг юм. Зүрхэн хэлхээ хийж, үүнийг өөртөө сануул! Цаасаар зүрх хайчлаад, зүрх бүр дээр гэр бүлийн гишүүнийхээ нэрийг бич. Зүрхнүүдээ нүхлээд, утсаар хэлхэж, нэгтгэ. Зүрхэн хэлхээгээ нүдэнд байнга ил харагдах газар өлгө!

Бага насны хүүхдүүдэд:

Хүүхдээсээ гэр бүлийн гишүүн бүрийн юунд нь дуртайг асуу. Хүүхдийнхээ бусдад хайраа харуулахаар хийдэг зүйлсийн талаар тэдэнд хэлж өгөөрэй!

